

НИЙГМИЙН АЖИЛТНЫ ЁС ЗҮЙН ДҮРМИЙН ТӨСӨЛ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү ёс зүйн дүрэм нь (цаашид “дүрэм” гэх) нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээ, үйл ажиллагаанд баримтлах үнэт зүйлс, зарчмуудыг тодорхойлох, төрийн болон төрийн бус байгууллагуудын нийгмийн ажлын үйлчилгээ, мэргэжлийн удирдлага, шийдвэр гаргах үйл явцад мөрдөх ёс зүйн хэм хэмжээг тогтоох, нийгмийн бүх түвшинд нийгмийн ажилтны баримтлах мэргэжлийн ёс зүйн үүрэг хариуцлагыг тодорхойлох, ёс зүйн дүрэм зөрчигдсөн тохиолдлуудад дүн шинжилгээ хийж, шийдвэрлэхтэй холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Нийгмийн ажилтан нийгмийн ажлын олон талт үйлчилгээг хүргэхдээ Монгол Улсын Үндсэн хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль Нийгмийн халамжийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хууль болон олон улсын гэрээ конвенци, бусад холбогдох хууль, эрх зүйн актыг удирдлага болгоно.

Хоёр. Хамрах хүрээ

2.2. Энэхүү дүрэм нь хөдөлмөр, нийгмийн хамгаалал, боловсрол, эрүүл мэнд, хууль сахиулах, нийгмийн хөгжил, хүний эрхийг хангах зэрэг нийгмийн бүх салбарт ажиллаж, мэргэжлийн шууд ба шууд бус үйлчилгээг үзүүлж байгаа нийгмийн ажилтан, нийгмийн ажлын багш, судлаач, оюутан, нийгмийн ажлын мэргэжлийн нийгэмлэгт хамаарна.

Гурав. Нийгмийн ажлын үнэт зүйлс, зарчмууд

3.1. Нийгмийн ажилтан нийгмийн ажлын мэргэжлийн үйл ажиллагаа, үйлчилгээнд дараах үнэт зүйлсийг баримтлана.

- 3.1.1. хүний эрх, нэр төрийг хүндэтгэх;
- 3.1.2. нийгмийн шударга ёсны төлөө тэмцэх;
- 3.1.3. хүний төрөлхийн үнэ цэнэ, эрхэмсэг чанарыг хүндэтгэх;
- 3.1.4. хүмүүс хоорондын харилцаанд ач холбогдол өгөх;
- 3.1.5. мэргэжлийн нэр төрийг хамгаалах.

3.2. Нийгмийн ажилтан 3.1.1-т заасан хүний эрх, нэр төрийг хүндэтгэх үнэт зүйлийг хэрэгжүүлэхэд дараах зарчмуудыг баримтална. Үүнд:

3.2.1. Хүний нэр төр, давтагдашгүй байдлыг хүндэтгэх;

3.2.2. Хүний өөрийгөө тодорхойлох эрхийг хүндэтгэн үйлчлүүлэгчийн хүсэл, сонирхол, үйлдэл нь бусад хүний эрх болон хууль ёсны ашиг сонирхолтой зөрчихгүй тохиолдолд үйлчлүүлэгчийг өөрөө бие дааж сонголт хийх, шийдвэр гаргах эрхийг хүндэтгэх, дэмжих;

3.2.3. Хувь хүн, гэр бүл, бүлэг, олон нийтийн нийгэм, соёлын болон бусад ялгаатай байдлыг хүндэтгэх;

3.2.4. Үйлчлүүлэгчийн давуу тал, нөөц боломжийг нэмэгдүүлэх, хөгжүүлэх, чадваржуулахад анхаарах

3.3. Нийгмийн ажилтан 3.1.2-т заасан нийгмийн шударга ёсны төлөө тэмцэх үнэт зүйлийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална. Үүнд:

3.3.1. Хүний нас, хүйс, арьсны өнгө, соёлын онцлог, нийгэм, эдийн засгийн болон гэр бүлийн байдал, улс төрийн үзэл бодол, бэлгийн чиг баримжаа, шашин шүтлэг зэргээр ялгаварлан гадуурхахгүй байх;

3.3.2. хувь хүн, гэр бүл, бүлэг, байгууллага, олон нийтийн нийгмийн амьдралд оролцох оролцоог дэмжин, хамтран ажиллах;

3.3.3. нийгмийн шударга ёсыг хэрэгжүүлэхэд саад болж буй хүчин зүйлийг багасгах, нийгмийн гишүүдийн нөөц боломж, сонголтыг өргөжүүлэхийн төлөө ажиллах;

3.3.4. нийгмийн баялаг/нөөцийг шударга хуваарилах, ялангуяа нийгмийн баялгаас хүртэх боломж хязгаарлагдмал байгаа бүлгүүдэд нийгмийн баялагийг шударгаар хуваарилах, хүртэх боломжийн төлөө ажиллах;

3.3.5. шударга бус, тэгш бус байдалд шүүмжлэлтэй хандах, шударга бус байдлыг бий болгож байгаа нийгмийн бүтцийг өөрчлөхийн төлөө ажиллах;

3.3.6. хүний эрхийн зөрчлийг илрүүлэхэд оролцох, эрх нь зөрчигдсэн үйлчлүүлэгчид нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх, холбон зуучлах, хүний эрхийн төлөө бүх түвшинд нөлөөллийн ажил хийх;

3.4. Нийгмийн ажилтан 3.1.3-т заасан хүний төрөлхийн үнэ цэнэ, эрхэмсэг чанарыг хүндэтгэх мэргэжлийн үнэт зүйлийг хэрэгжүүлэхэд дараах зарчмуудыг баримтална. Үүнд:

3.4.1. хүний хандлага, үг хэллэг, үйлдэлд илрэх өөрийн болон бусдын төрөлхийн үнэ цэнэ, эрхэмсэг чанарыг үгүйсгэх итгэл үнэмшил, үйлдлийг илрүүлэн арилгахын төлөө ажиллах;

3.4.2. үйлчлүүлэгчийн эрх, ашиг сонирхлыг нэн тэргүүнд анхаарах;

3.4.3. хуульд заасан мэдээлэх үүргээс бусад тохиолдолд үйлчлүүлэгчтэй холбоотой мэдээллийн нууцыг чанд хадгалах;

3.4.4. үйл ажиллагаа, үйлчилгээ нь бусдад хор хөнөөл учруулахгүй байх;

3.4.5. үйлчлүүлэгчийг нэг бүхэл тогтолцоо гэж үзэн үйлчлүүлэгчийн оролцоотойгоор түүний биологи, сэтгэл зүй, нийгэм, итгэл үнэмшлийн бүхий талуудыг таньж, нийгмийн ажлын цогц үйлчилгээ хүргэх;

3.4.6. Үйлчлүүлэгчийн эрх мэдэл, өөртөө итгэх итгэл, өөрчлөлт хийх итгэлийг нэмэгдүүлэхэд туслах

3.5. Нийгмийн ажилтан 3.1.4-т заасан хүмүүс хоорондын харилцаанд ач холбогдол өгөх мэргэжлийн үнэт зүйлийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална. Үүнд:

3.5.1. Хүмүүс хоорондын харилцааны талаарх мэдлэг, дадал, хандлагын сайтар эзэмшсэн байх

3.5.2. Нийгмийн ажилтны мэргэжлийн үйл ажиллагааны гол арга хэрэгсэл нь хүмүүс хоорондын харилцаа, хамтын ажиллагаанд тулгуурлах

3.5.3. Хувь хүн, гэр бүл, бүлэг, байгууллага, олон нийтийн сайн сайхан байдлыг нэмэгдүүлэх, хамгаалах, нөхөн сэргээх зэрэгт хүмүүс хоорондын харилцааг бэхжүүлэхэд анхаарлаа хандуулах

3.6. Нийгмийн ажилтан 3.1.5-т заасан мэргэжлийн нэр төрийг хамгаалах үнэт зүйлийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална. Үүнд:

3.6.1. нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээ, үйл ажиллагаа явуулахад шаардлагатай мэдлэг, ур чадвар, хандлагыг эзэмшсэн байх;

3.6.2. нотолгоонд суурилсан үр дүнтэй үйлчилгээг үзүүлэхийн тулд мэдлэг, ур чадвар, хандлагаа эргэцүүлэн дүгнэж, тасралтгүй хөгжүүлэх;

3.6.3. мэргэжлийн дэмжин туслалцаа авах тогтолцоог бий болгох, хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах;

3.6.4. эрх мэдэл, байр сууриа хэтрүүлэх, бэлгийн дарамт, шахалт үзүүлэх, хамтрагч болон үйлчлүүлэгчийн итгэлийг эвдэн буруугаар ашиглах зэрэг шударга бус үйлдэл хийхгүй байх;

3.6.5. хүчирхийлэл, садар самуун явдал, аллага, терроризм, хүнийг үй олноор устгах цэргийн болон бусад ямар ч хүмүүнлэг бус үйл ажиллагаанд мэргэжлийн мэдлэг, ур чадварыг ашиглахгүй байх;

3.6.6. Нийгмийн ажлын мэргэжлийн хөгжилд хувь нэмрээ оруулах.

Дөрөв. Нийгмийн ажилтны ёс зүйн хэм хэмжээ

4.1. хувь хүний нэр төр, давтагдашгүй байдлыг хүндэтгэхэд дараах ёс зүйн хэм хэмжээг мөрдөнө. Үүнд:

4.1.1. үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд аюул учруулахгүй ажиллана.

4.1.2. хүний нэр төрийг дээдэлж, хор хохирол учруулж болохгүй.

4.2. Хүний өөрийгөө тодорхойлох эрхийг хүндэтгэн үйлчлүүлэгчийн хүсэл, сонирхол, үйлдэл нь бусад хүний эрх болон хууль ёсны ашиг сонирхолтой зөрчихгүй тохиолдолд үйлчлүүлэгчийг өөрөө бие дааж сонголт хийх, шийдвэр гаргах эрхийг хүндэтгэх, дэмжих, ялгаатай байдлыг хүндэтгэхэд дараах ёс зүйн хэм хэмжээг мөрдөнө. Үүнд:

4.2.1. үйлчилгээг үзүүлэхээс өмнө үйлчлүүлэгчдээ ямар үйлчилгээ авах боломжууд байгааг ойлгуулсан байна.

4.2.2. үйлчлүүлэгчдээ үзүүлэх үйлчилгээний хэлбэр, үргэлжлэх хугацаа, хязгаарлагдмал болон сул тал байгаа эсэхийг тайлбарлаж ойлгуулан, тэмдэглэл хөтлөнө.

4.2.3. үйлчилгээний хувилбараас сонголт хийхэд нь туслах, үйлчлүүлэгч албадлагаар үйлчилгээ авах шаардлагатай тохиолдолд үйлчилгээний журам, үйлчилгээ үзүүлэх төлөвлөгөөг сайтар танилцуулж ойлгуулна.

4.2.4. үйлчлүүлэгч бүрт үйлчилгээ үзүүлэх төлөвлөгөө боловсруулах ба төлөвлөгөө нь үйлчилгээний төрөл, зорилго, хүлээгдэж буй үр дүн, арга зам, үйлчилгээг сонгосон шалтгаан зэргийг агуулсан байна.

4.2.5. дүрмийн 4.2.4-т заасан төлөвлөгөөг тодорхой хугацаанд шинэчилнэ.

4.3. Нийгмийн ажилтан нь хувь хүнийг түүний гадаад орчинтой нь цогц байдлаар авч үзэх ба үйлчлүүлэгчийн амьдралын бүхий л хүрээг хамруулан хандана.

4.4. Нийгмийн ажилтан нь хувь хүн, гэр бүл, бүлэг, олон нийтийн давуу талыг олж илрүүлэн, тэдний давуу талыг нэмэгдүүлэх, хөгжүүлэх, чадваржуулахад анхаарч ажиллах ба үйлчлүүлэгчийн нөхцөл байдал, тулгарч буй эрсдлийг үнэлэхдээ дараах хүрээг хамруулан авч үзнэ. Үүнд:

4.4.1. үйлчлүүлэгчийн нийгэм-сэтгэл зүй, биологи ба бүтцийн онцлог, хөгжлийн үе шатуудын тухай мэдлэг, мэдээллийг тухайн үйлчлүүлэгчийн нөхцөл байдалтай холбон судална.

4.4.2. үйлчлүүлэгчид тулгарах аливаа эрсдлийг үйлчлүүлэгч ба оролцогч талуудын зан үйл, орчны хүчин зүйлс, бусад эрсдэлтэй холбон судална.

4.4.3. үйлчлүүлэгчид тулгарч буй асуудлыг нийгмийн бүтэц, хүчин зүйлстэй холбон тодорхойлно.

4.4.4. нийгмийн тогтолцооны нөлөө болох хууль эрх зүй, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбарын зүгээс үйлчлүүлэгчид үзүүлэх нөлөөг харгалзан үзнэ.

4.4.5. үйлчлүүлэгчийн давуу тал, нөөц боломжийг илрүүлнэ.

4.4.6. үйлчлүүлэгчид тохиолдож байгаа эрсдэлтэй нөхцөл байдлын түвшинг үнэлж, түүнийг таслан зогсоох, багасгах арга хэмжээ авна.

4.5. Нийгмийн ажилтан нь нийгмийн шударга ёсыг дэмжин, нийгмийн бүх хүрээнд шударга ёсыг хангахын төлөө ажиллахдаа дараах ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө. Үүнд:

4.5.1. авъяас чадвар, нас, соёлын онцлог, хүйс, гэр бүлийн байдал, нийгэм эдийн засгийн байдал, улс төрийн үзэл бодол, арьсны өнгө, бэлгийн чиг баримжаа, шашин шүтлэг зэрэг ялгаатай байдлыг үндэслэн хэн нэгнийг ялгаварлан гадуурхах явдлыг эсэргүүцнэ.

4.5.2. үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхдээ хувь хүн, гэр бүл, бүлэг, байгууллага, олон нийт болон нийгмийн ялгаатай байдлыг харгалзан тэдний соёл, зан суртахууны ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч хүндэтгэн үзнэ.

4.5.3. өөрийн мэдэлд байгаа нөөцийг шударга хуваарилна.

4.5.4. нийгмийн хүрээнд төлөвлөсөн хөрөнгө шаардлага хангахгүй байгаа болон түүнийг хуваарилах талаар явуулж буй бодлого, үйл ажиллагаа нь шударга бус, нэг талыг хэт барьсан, муу үр дүнтэй байгаа үед эрх баригчид, улс төрчид, албан тушаалтнууд болон өргөн олон нийтийн анхаарлыг түүнд хандуулж, шудрага бус бодлого, үйл ажиллагаатай тэмцэж, засаж сайжруулахын төлөө ажиллана.

4.5.5. үйлчлүүлэгчийн орчинд бүхлээр нь хандсан үйл ажиллагаа явуулж, хүмүүсийг гарал үүслээр нь ялгаварлан гадуурхахгүй байх, захиран тушааж, ялгаа үүсгэхгүй байх нийгмийн нөхцөл байдалд анхаарлаа хандуулж, эв нэгдлийг хангах үйл ажиллагаа явуулна.

4.6. хүний хандлага, үг хэллэг, үйлдэлд илрэх өөрийн болон бусдын төрөлхийн үнэ цэнэ, эрхэмсэг чанарыг үгүйсгэх итгэл үнэмшил, үйлдлийг илрүүлэн арилгахын төлөө ажиллахад дараах ёс зүйн хэм хэмжээг баримтална. Үүнд:

4.6.1. хүний хандлага, үг хэллэг, үйлдэлд илрэх өөрийн төрөлхийн үнэ цэнэ, эрхэмсэг чанарыг үгүйсгэх итгэл үнэмшил, үйлдлийг илрүүлнэ.

4.6.2. хүний хандлага, үг хэллэг, үйлдэлд илрэх өөрийн төрөлхийн үнэ цэнэ, эрхэмсэг чанарыг үгүйсгэх хандлагыг арилгахад чиглэсэн асуудалд соёлын мэдрэмжтэй хандана.

4.7. үйлчлүүлэгчийн эрх, ашиг сонирхлыг нэн тэргүүнд анхааран ажиллахад дараах ёс зүйн хэм хэмжээг баримтална. Үүнд:

4.7.1. үйлчлүүлэгчийн өөрийн зорилгоо тодорхойлоход нь тусалж, өөрийгөө тодорхойлох байдлыг хүндэтгэнэ.

4.7.2. үйлчлүүлэгчийн өөрийгөө тодорхойлох эрхийг хүндэтгэн ажиллахдаа тэдэнд учирч болзошгүй эрсдэлийг тооцож, шүүмжлэлтэй хандаж болно.

4.8. үйлчлүүлэгчтэй холбоотой мэдээллийн нууцыг чанд хадгалахад дараах ёс зүйн хэм хэмжээг баримтална. Үүнд:

4.8.1. үйлчлүүлэгчтэй холбоотой мэдээллийн нууцыг “Хүүхэд хамгааллын тухай хууль”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”-иудад заасан мэдээлэх, үйлчлүүлэгч болон гуравдагч этгээдийн аюулгүй байдлын хамгаалахтай холбоотой үүргээ биелүүлэх, “Хувь хүний нууцын тухай хууль”, -ийн 6 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд түүнийг амьд сэрүүн байх хугацаанд төдийгүй нас барсных нь дараа ч чандлан хадгална.

4.8.2. Үйлчлүүлэгч болон үйлчилгээний талаарх мэдээллийг сургалт, судалгааны зорилгоор ашиглах, хэвлэл мэдээллээр олон нийтэд мэдээлэхдээ үйлчлүүлэгч болон удирдлагын зөвшөөрлөөр мэдээлнэ.

4.9. үйл ажиллагаа, үйлчилгээ нь хор хөнөөл учруулахгүй байх, цогц үйлчилгээ хүргэхэд дараах ёс зүйн хэм хэмжээг баримтална. Үүнд:

4.9.1. Үйл ажиллагаа, үйлчилгээ нь хор хохирол учруулахгүй байх, хор хохиролыг хамгийн бага байлгахад чиглэнэ.

4.9.2. Үйлчлүүлэгчийн нөхцөл байдлыг үнэлгээ нь түүний биологи, сэтгэл зүй, нийгэм, итгэл үнэмшлийн бүхий л талуудыг танин мэдэхэд чиглэх бөгөөд цогц үйлчилгээг үзүүлнэ.

4.10. Үйлчлүүлэгчийн эрх мэдэл, өөртөө итгэх итгэл, өөрчлөлт хийх итгэлийг нэмэгдүүлэх дараах ёс зүйн хэм хэмжээг баримтална. Үүнд:

4.10.1. хүчин мөхөс хувь хүн, бүлэгт амьдралын нөхцөлөө сайжруулахтай холбоотой эрх мэдлийн талаарх ойлголт мэдлэг, өөртөө итгэлийг нэмэгдүүлэхэд анхаарна.

4.10.2. үйлчлүүлэгч өөрийн болон бусдын төлөө өөрчлөлт хийхэд нь туслана.

4.11 Хүмүүс хоорондын харилцааны талаарх мэдлэг, дадал, хандлагын сайтар эзэмшсэн байх, хүмүүс хоорондын харилцаа хамтын ажиллагааг эрхэмлэхэд дараах ёс зүйн хэм хэмжээг баримтална. Үүнд:

4.11.1. Хүмүүс хоорондын харилцааны аман болон биеийн, бичгийн хэлбэрүүд мэргэжлийн үйл ажиллагаандаа зохистой ашиглана.

4.11.2. мэргэжил нэгт нөхөд, байгууллага хоорондын харилцааны үр нөлөөтэй хэлбэрийг ашиглахыг эрмэлзэнэ.

4.12. нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээ, нотолгоонд тулгуурласан үйл ажиллагаа явуулахад дараах ёс зүйн хэм хэмжээг баримтална. Үүнд:

4.12.1. нийгмийн ажилтан нь өөрийн үйл ажиллагаанд зайлшгүй хэрэгтэй мэргэжлийн мэдлэг, чадвар, дадал эзэмшиж, түүнийгээ байнга хөгжүүлнэ.

4.12.2 нийгмийн ажилтан нь үйлчлүүлэгчийн нөхцөл байдлыг үнэлэх, чанартай үйлчилгээ хүргэх, үнэлгээнд үндэслэн үйлчлүүлэгчийг шилжүүлэх талаар мэдлэг, чадвартай байна.

4.12.3. нийгмийн ажлын судалгааг хийхдээ судалгаанд оролцогчоос таниулсан зөвшөөрлийг авна.

4.12.4. нийгмийн ажилтан нь мэргэжлийн болон хувь хүний хувьд өөрийгөө тасралтгүй хөгжүүлэх сургалтуудад хамрагдахад анхаарч ажиллана.

4.13. мэргэжлийн дэмжин туслалцаа авах тогтолцоог бий болгох, хөгжүүлэх, нийгмийн ажлын мэргэжлийн үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулахад дараах ёс зүйн хэм хэмжээг баримтална. Үүнд:

4.13.1. нийгмийн ажилтан нь өндөр ур чадвартай ирээдүйн нийгмийн ажилтныг бэлтгэхэд хувь нэмрээ оруулж, нийгмийн ажлын чиглэлээр суралцаж байгаа оюутнуудыг сургах чиглэлээр нийгмийн ажлын сургуулиудтай хамтран ажиллана.

4.13.2. Нийгмийн ажилтны мэргэжлийн үйл ажиллагаанд ёс зүйн хоёрдмол байдал үүссэн тохиолдолд мэргэжлийн удирдлагатай зөвлөлдөж, ёс зүйн шийдвэр гаргах загварын дагуу судалж шийдвэр гаргана.

4.13.3. нийгмийн ажлын онол, арга зүйг боловсронгуй болгоход чиглэсэн судалгааны хийх, үр дүнг түгээхэд оролцохыг эрхэмлэнэ.

4.14. нийгмийн ажилтан нь хийж гүйцэтгэсэн ажлынхаа төлөө өөрийн үйлчлүүлэгч, хамтран зүтгэгчид, ажил олгогч, мэргэжлийн холбоод болон хуулийн өмнө хариуцлага хүлээнэ.

Тав. Нийгмийн ажилтны баримтлах мэргэжлийн ёс зүйн үүрэг, хариуцлага.

5.1. Нийгмийн ажилтан мэргэжлийн үйл ажиллагаа, үйлчилгээ хүргэж байхдаа үйлчлүүлэгч, нийгмийн үйлчилгээний байгууллага, мэргэжил нэгт нөхөд, нийгмийн өмнө хариуцлага хүлээнэ.

5.2. Нийгийн ажилтан энэ дүрмийн 5.1-т дурдсан үйлчлүүлэгчийн өмнө дараах үүрэг, хариуцлага хүлээнэ. Үүнд:

5.2.1. хувь хүний онцлогийг харгалзан үйлчлүүлэгчтэй харилцана.

5.2.2. үйлчлүүлэгчийн хүсэл сонирхлыг хүндэтгэн үзэж, үйлчлүүлэгчийн сайн сайхан байдлыг хангахын төлөө ажиллана.

5.2.3. үйлчлүүлэгч үйлчилгээг сонгох болон өөрийгөө тодорхойлох эрхийг нь дэмжинэ.

5.2.4. үйлчлүүлэгчийн хувийн амьдрал, эрхэмсэг чанарыг нь хүндэтгэнэ.

5.2.5. үйлчлүүлэгчийн оролцож байгаа нийгмийн ажлын үйлчилгээ, судалгаа ба үйл ажиллагааны талаар үйлчлүүлэгчид ойлгомжтой, тодорхой хэлбэрээр танилцуулж, үйлчлүүлэгчид бүрэн мэдээлэлтэй, сонголт хийх эрхтэйгээр оролцох боломж олгоно.

5.2.6. нийгмийн ажлын төрөл бүрийн үйлчилгээ авах, нийгмийн баялгаас хүртэх, мэдээллээр хангагдах зэрэг нийгмийн үйлчилгээний бүхий л шатанд үйлчлүүлэгч тэгш оролцох боломжоор хангахын төлөө ажиллана.

5.2.7. үйлчлүүлэгчид чиглэсэн аливаа үйлчилгээг нийгмийн ажлын үнэт зүйлс, шинжлэх ухааны баримт нотолгоо, мэдлэг, ур чадварт дээр тулгуурлан үзүүлнэ.

5.2.8. үйлчлүүлэгчийн соёл, үнэт зүйлд хүндэтгэлтэй хандаж, хүмүүсийн ялгаатай байдлыг ойлгон үйлчилгээг хүргэнэ.

5.2.9. нийгмийн ажлын үйлчилгээ эхлэхээс дуусах хүртэлх бүх шатанд үйлчлүүлэгчийн хэрэгцээ, сонирхолд нийцүүлэн бүрэн гүйцэд, мэргэжлийн түвшинд үйлчилгээг хүргэнэ.

5.2.10. нийгмийн ажлын үйлчилгээний үйл явцад видео бичлэг хийх, дуу хураагч ашиглах, гуравдагч этгээдийг ажиглагчаар оролцуулахдаа үйлчлүүлэгчээс зөвшөөрөл авна.

5.2.11. нийгмийн ажлын үйлчилгээний үед нийгмийн ажилтанд сонирхлын зөрчил үүссэн үед үйлчлүүлэгчийн ашиг сонирхлыг эн тэргүүнд тавина.

5.3. Нийгмийн ажилтан энэ дүрмийн 5.1-т дурдсан нийгмийн үйлчилгээний байгууллагын өмнө дараах үүрэг, хариуцлага хүлээнэ. Үүнд:

5.3.1. нийгмийн ажилтны мэргэжлийн ёс зүйн зарчимд нийцэхүйц үйлчилгээ, мэргэжлийн үйл ажиллагааг дэмжих бодлого, журам арга хэмжээ авч хэрэгжүүлдэг байгууллагатай хамтран ажиллана.

5.3.2. байгууллагын үүрэг даалгавар, зорилгыг хариуцлагатайгаар гүйцэтгэнэ.

5.3.3. зөв зохистой бодлого, журам, үйл ажиллагааг хөгжүүлэх, нийгмийн ажлын мэргэжлийн удирдлагыг боловсронгуй болгоход байгууллагадаа хувь нэмэр оруулахыг зорино.

5.3.4. байгууллагын үйлчилгээ, түүний чанарт байнга хяналт тавих замаар нийгмийн ажилтнуудын үйл ажиллагааны эцсийн үр дүнг баталгаажуулж, нийгэм, үйлчлүүлэгчдийн өмнө хүлээсэн үүрэг, хариуцлагыг өндөржүүлнэ.

5.3.5. байгууллагын бодлого, журам, хэвшмэл үйл ажиллагаа нь нийгмийн ажлын ёс зүйн зарчмуудтай илт зөрчилдөж буй тохиолдолд ёс зүйд нийцэх бүх арга замаар асуудлыг шийдэхийг зорино.

5.3.6. нийгмийн ажилтны мэргэжлийн үйл ажиллагаанд бэрхшээл учруулах хувийн шинжтэй асуудлыг удирдлагадаа мэдээлнэ.

5.4. Нийгмийн ажилтан энэ дүрмийн 5.1-т дурдсан мэргэжил нэгт нөхдийн өмнө дараах үүрэг, хариуцлага хүлээнэ.

5.4.1. мэргэжлийн нийгмийн ажилтны боловсрол, дадлага туршлага, чадварыг үнэлж хүндэтгэх, тэдгээрийн үйл ажиллагааны үр өгөөжийг дээшлүүлэх бүх талын дэмжлэг, туслалцааг үзүүлнэ.

5.4.2. нийгмийн ажилтнууд болон мэргэжлийн хүмүүсийн хоорондын үзэл бодол, үйл ажиллагааны онцлог, ялгааг хүлээн зөвшөөрч, шүүмжлэлийг тодорхой ойлгомжтой илэрхийлнэ.

5.4.3. бусад мэргэжлийн ажилтан, сайн дурын ажилтантай хамтран ажиллаж, төрөл бүрийн боломж, бололцоог хуваалцах, мэдээлэл, туршлага солилцох, нээлттэй хамтран ажиллана.

5.4.4. мэргэжлийн ёс зүйн болон бусад хэм хэмжээг зөрчсөн үзэгдлийг холбогдох байгууллага, үйлчлүүлэгчдэд зохих ёсоор мэдэгдэнэ.

5.4.5. мэргэжил нэгт нөхдөө шударга бус үйлдлээс хамгаална.

5.5. Нийгмийн ажилтан энэ дүрмийн 5.1-т дурдсан нийгмийн өмнө дараах үүрэг, хариуцлага хүлээнэ.

5.5.1. нийгмийн өмнө мэргэжлийн үнэт зүйлс, ёс зүйн зарчим, мэдлэг, арга барилыг баримталж, тэдгээрийг тодотгох, сайжруулах талаар анхаарч ажиллана.

5.5.2. өөрийн мэргэжлийг шударга бус шүүмжлэлээс хамгаалж, нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээ зайлшгүй шаардлагатай гэдэг итгэлийг баталгаажуулах талаар чармайн ажиллана.

5.5.5. нийгмийн ажил, мэргэжлийн онол, арга зүйн талаар бүтээлчээр санал дэвшүүлнэ.

5.5.6. нийгмийн бодит байдал, шинээр гарч буй хэрэгцээ шаардлагыг шийдвэрлэх, арга зүйг дэмжин нэвтрүүлнэ.

Зургаа. Монголын нийгмийн ажилтны ёс зүйн үндэсний болон салбар хороо

6.1. Дүрмийг хэрэгжүүлэх, хяналт тавих асуудлаар Монголын нийгмийн ажилтны ёс зүйн үндэсний хороо /цаашид үндэсний хороо гэх/ хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд ажиллана.

6.2. Үндэсний хороо нь салбар хороодтой байх ба салбар хороог аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэд байгуулж, ажиллуулна.

6.3. Нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан ёс зүйн хорооны үлгэрчилсэн дүрэмд үндэслэн үндэсний болон салбар хороо нь үйл ажиллагааны нарийвчилсан дүрмээ боловсруулна.

6.4. Үндэсний хорооны дүрмийг Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, салбар хорооны дүрмийг аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн хамгааллын асуудал хариуцсан дарга батална.

6.5. Ёс зүйн дүрэмд заагдаагүй асуудлыг ёс зүйн үндэсний болон салбар хороогоор хэлэлцэх тохиолдолд Нийгмийн ажилтны олон улсын ёс зүйн дүрмийг дагаж мөрдөнө.

6.6. Үндэсний болон салбар хорооны бүтэц, зохион байгуулалт

6.6.1. Үндэсний хороо нь 15 гишүүнтэй байх ба хөдөлмөр нийгмийн хамгаалал, боловсрол соёл шинжлэх ухаан, спорт, хууль зүй дотоод хэрэг, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тус бүрээс нэг, нийгмийн ажилтан бэлтгэдэг их дээд сургуулиудаас дөрөв, мэргэжлийн нийгэмлэг,

холбоодоос дөрөв, анхан шатанд нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлж буй нийгмийн ажилтны гурван төлөөлөл тус тус багтана.

6.6.2. Төрийн захиргааны төв байгууллагын холбогдох албан тушаалтнаас бусад үндэсний хорооны гишүүдийг сонгохдоо нийгмийн ажлын мэдлэг, чадвар, туршлага, ёс зүйн зөрчил гаргаагүй эсэхийг илтгэсэн байгууллага, салбар нэгжийн тодорхойлолт, нэр дэвшүүлж буй байгууллага, холбооны хурлын протокол, нэр дэвшигчийн өргөдөл, анкет зэргийг харгалзан сонгон шалгаруулалтаар Үндэсний болон салбар хорооны гишүүн болно.

6.6.3. Үндэсний хорооны гишүүнд нэр дэвшүүлэх сургууль, мэргэжлийн холбоо, анхан шатны байгууллага нь (а) 3-аас цөөнгүй орон тооны ажилтантай; (б) үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангаа гишүүддээ ил тод мэдээлдэг; (в) сүүлийн гурван жилд 100-аас доошгүй суралцагч, төгсгөгч, гишүүн, үйлчлүүлэгч оролцуулан тасралтгүй үйл ажиллагаа явуулсан байна.

6.6.4. Үндэсний хорооны гишүүнээр нийгмийн ажлын мэргэжлээр бакалавр, магистраас доошгүй зэрэгтэй, мэргэжлээрээ таваас доошгүй жил ажилласан туршлагатай, ёс зүйн зөрчил гаргаагүй, хамт олныхоо дунд нэр хүндтэй байх гэсэн үндсэн шаардлага хангасан байна.

6.6.5. Үндэсний болон салбар хорооны гишүүд дотроосоо нэг гишүүнээ нууцаар санал хурааж даргаар сонгоно.

6.6.6. Үндэсний хорооны гишүүдийг хоёр жил тутам шинэчилж сонгоно. Сонгон шалгаруулах гишүүний 30 хүртэлх хувийн гишүүн нэг удаа улиран сонгогдоно.

6.6.7. Үндэсний болон салбар хорооны гишүүн нээлттэй сонгон шалгаруулалтыг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн төв байгууллага ахлан, үндэсний хороо, нийгмийн ажлын сургуулиуд, мэргэжлийн холбоодын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг зохион байгуулна.

6.6.8. Салбар хороо нь 7-9 хүний бүрэлдэхүүнтэй байна.

Долоо. Ёс зүйн хариуцлага

7.1. Ёс зүйн зөрчилтэй холбоотой өргөдөл, гомдлыг салбар хороо хүлээн авч дүгнэлт гаргах, шаардлагатай тохиолдолд үндэсний хороонд уламжлан ёс зүйн зөрчил болон мэргэжлийн үйл ажиллагааны талаарх шинжээчийн дүгнэлт гаргана.

7.2. Ёс зүйн хорооны шинжээчийн дүгнэлт нь Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйл, бусад хууль, байгууллагын дүрэмд заасан хөдөлмөрийн сахилгын шийтгэл оногдуулах үндэслэл байж болно.

7.3. нийгмийн ажилтан мэргэжлийн ёс зүйн зөрчил гаргасан нь тогтоогдсон, нийгмийн ажилтын ёс зүйн үндэсний хорооны болон салбар хорооны шийдвэрийг биелүүлээгүй ажилтанд холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

-----oOo-----